

В.ИНЖАННАШИЙН “ХӨХ СУДАР” РОМАНЫ УРАН ДҮРИЙН ХЭЛНИЙ АСУУДАЛД

В. Янжиндулам *

Аливаа зохиолчийн урлан бүтээх туршлага, туурвилзүйн онцлог нь уран сайхны үнэнг зохиолч өөрийн ертөнцийг үзэх үзэл, уран сэтгэлгээгээр ургуулан боловсруулж, чухам яаж илэрхийлснээр тодорхойлогдоно. Ер нь хэл яриа нь уран зохиолын дүр бүтээх үндсэн арга хэрэгсэл, түүхий эд нь болдог учраас уран дүрийн асуудлыг тухай зохиолыг оршин тогтноход хүргэж буй хэлээс ангид авч үзэх боломжгүй юм. Ийм ч учраас уран зохиолын онолын сэтгэлгээний бүх түүхийн туршид аливаа зохиол бүтээлийн хэл найруулгын судалгаанд онцгой анхаарал хандуулж ирсэн билээ. “Нэн ялангуяа XX зууны утга зохиолын онолын ихээхэн нэр хүнд бүхий чиглэл болох формалист онолын чиглэл нь "утга зохиол шинжлэлийг үндсэндээ тухайн бүтээлийн хэлний судалгаанд гол анхаарлаа хандуулах ёстой" гэж үзэж байсан бөгөөд "утга зохиол шинжлэл нь уран сайхны хэлбэрийг бүрдүүлэгч гол хүчин зүйл болох хэл найруулгын судалгаа юм" гэсэн томъёолол ч дэвшүүлж”¹ байсныг бодоход уран дүрийн үгсийн сан, зохиолчийн хэл найруулгын судалгаа нэн чухал байна. Философид үзэл санаа нь үзэл санаа л байдаг бол урлагт үзэл санаа нь хэлбэр байдаг. Өөрөөр хэлбэл урлагийн үзэл санаа нь уран сайхны хэлбэр болох уран сайхны дүр, уран сайхны бүтэц байгууламж, уран сайхны хэл найруулгаар дамжин илэрдэг.

В.Инжаннашийн Хөх судар романы уран сайхны талыг илт өргөн эрдэмтэн судлаачдын дуу нэгтэй уран зохиол гэж үзэхэд хүргэдэг увдис чадал нь түүний уран дүрийн боловсруулалт, дүрслэхүйн ур ухаан, утга төгөлдөр яруу тансаг хэл найруулгад нь оршино.Тиймээс ч эрдэмтэн монгол судлаач Г.Михайлов “анхны монгол роман”² эрдэмтэн Г.Буянбат “түүхэн үлгэр”³, эрдэмтэн Ч.Билигсайхан “ууган түүхэн роман”⁴ эрдэмтэн Дэлгэр “түүх биш уран зохиол”⁵ зэргээр үнэлж дүгнэсэн нь бий.

Эрдэмтэн Десрейжав “Их зохиолч Инжаннашийн урнаар өгүүлэх аргын тухай”⁶ “Хөх судрын хэл хэллэгийн онцлогийг туршин өгүүлэх нь”⁷, “Инжаннашийн үг

* МУИС, Ховд их сургууль

¹ Энхбаяр. С (2011), Утга зохиолын онол, Улаанбаатар, 60-р тал.

² Михайлов.Г, Яцковская. (1969), К. Монгольская литература. Москва, 16-р тал.

³ Буянбат.Г (1988), Инжаннаши ба түүний Хөх сударын тухай, Хөх хот, 12-р тал.

⁴ Билигсайхан.Ч (1984), Орчин цагийн монгол роман, Улаанбаатар, 12-р тал.

⁵ Дэлгэр (1988), Хөх судрын гол баатрын зан чанарын бүтэц ба систем.-ӨМИС-ийн ЭШС. №3. 107-р тал.

⁶ Десрейжав (1983), Их зохиолч Инжаннашийн урнаар өгүүлэх аргын тухай. ӨМИС-ийн ЭШБ. №2

⁷ “МОНГОЛ ХЭЛ УРАН ЗОХИОЛ”, 1983, №1.

хэрэглэх уран мэргэжлийн тухай”⁸, Сүеэ “Алдарт зохиолч Инжаннаши хийгээд ардын аман зохиол”⁹, Ногоонжияага “Инжаннашийн зохиол бүтээл дэх уламжлал шинэчлэлийн ул мөр”¹⁰ зэрэг өгүүллүүд болон эрдэмтэн Б.Гэрэлтү “Монгол зохиолын онолын чимэг”(1998), “Монгол зохиолын онол өгүүлэхийн түүхэн шинжилгээ”(1998), Б.Содбилэг “Содбилэгийн зохиолын түүвэр” (1985), Десрейжав “Их зохиолч Инжаннаши”(1993), “Хөх судар хийгээд 10 анги судрын харьцаа” (1990), Эү Юүвэй “Инжаннаши ба түүний зохиол бүтээлийн тухай судлал” (2002), Эрдэнэтогтох “Инжаннашийн тухай судлал” (1988) зэрэг бие даасан бүтээлүүддээ Хөх судар романы хэл уран сайхан, дүр, түүхэн судруудтай харьцах харьцааны асуудлыг хөндөн тавьжээ. Эрдэмтэн судлаач Эрдэнэхад, Инжаннаши Хасбуу нарын уран бүтээлийн уран дүрслэх арга барилыг судлан шинжлээд “Органик зохицонгуй туурвих ухаан” (2001) бүтээл туурвин эрдмийн зэрэг хамгаалжээ.

В.Инжаннашийн “Хөх судар” романы уран дүр, дүрслэл, хэл найруулгын асуудлыг Өвөр монголын судлаач эрдэмтэн Г.Буянбат “Хөх судрын урлагийн амжилт”, “Хөх судрын илтгэх арга” гэдэг өгүүлэлдээ “Шууд илтгэх, тольтгол, адилтгал, зүйрлэл, харьцуулал, харилцан яриа, уянгалал, хүүрнэл, шүүмжлэн өгүүлэхүйн аргуудаар уран дүрийг бүтээсэн байна”¹¹ гэж үзжээ.

В.Инжаннаши нь түүхэн үйл явдыг уран цэцэн туурвин бичихдээ хэлний яруу сайхныг шилж сонгон утга уянга хослуулан яруу сонсголонтой байх зарчмыг барин, хэм тэгшлэн эс сондгойруулж 7000 гаруй хоршоо үгийг хэрэглэснийг эрдэмтэн Баасанбат¹² судлан гаргаж мөн зохиолынхэвшмэл хэлц хэллэгийг нь түүн ангилан ялгасан¹³ нь их зохиолчийн хэл найруулгаас суралцагч эх хэлээ үндэсний соёлоо өвлөн тээгч хэн бүхнээ нэн чухал судалгаа шинжилгээ болсон юм.

Уран дүр гэдэг тухайн зохиолын оршихуйн гол судас билээ. Урлаг уран сайхны аливаа туурвил уран дүрээс ангид оршихын аргагүй юм. Уран зохиолын гол сурвалж, гол сүнс нь үзэл санаа уран сайхан хоёрын зангилаа болсон уран дүр юм гэж тайлбарласан нь утга зохиолын онолын судалгааны хамгийн чухал асуудлыг хөндсөн шинжлэх ухааны гарцаагүй үнэн байсан юм.¹⁴ Оросын нэрт онолч Л.И.Тимофеев “Дүр гэдэг бол ургуулан бодох бодлын хүчээр бүтээсэн гоо зүйн учир холбогдол бүхий тодорхойн зэрэгцээ нэгтгэн төлөөлсөн хүний аж амьдралын дүр зураг”¹⁵ байдагчлан В.Инжаннашийн бүтээсэн дүрүүд нь зохиол бүтээгдэж байсан цаг үеийнхээ монгол тоотны амьдрал ахуйн нүднээ харагдахуйц яруу тодорхой тусгал болсон байдаг билээ. “Хөх судар”-ын дүр бүтээх урлагийн талаар эрдэмтэн Г.Буянбат “Хөх судар доторх хүмүүсийн дүр бол үнэн амьдралын өн шимлэг хөрс сууриас үндэс сурвалжтай мөртөө түүнээс нэн өндөр нэн хурц төвлөрүүн болсон хэв шинжит уран дүр болно” хэмээн дүгнэсэн байдаг.

Инжаннашийн дүр бүтээх онцлог нь түүний ертөнцийг үзэх үзэл, гүн ухааны баримтлал тухайн нийгэм цаг үедээ хандаж байсан хандлагатай салшгүй холбоотой

⁸) Десрейжав (1993), Их зохиолч Инжаннаши. Бээжин.

⁹) ӨМҮБДС-ийн ЭШБ, 1983, №1.

¹⁰) “АЛТАН ТҮЛХҮҮР”, 1992, №3.

¹¹) Буянбат.Г (1988), Инжаннаши ба түүний Хөх судрын тухай, ӨМАХХ. Хөх хот, 59-р тал.

¹²) Баасанбат.Д (2007), “Хөх судар”-ын хоршоо үгийн сан.

¹³) Баасанбат.Д Д (2007), “Хөх судар”-ын хоршоо үгийн сан.

¹³) Баасанбат.Д (2009), “Хөх судар”-ын хэвшмэл хэлц хэллэгүүд.

¹⁴) Байгальсайхан (1998), Уран дүрийн онолын лекцүүд, Улаанбаатар.

¹⁵) Тимофеев.Л.И (1959), Основы теории литературы, Москва, стр. 293.

болно. Их зохиолч Инжаннаши зүйрлэл адилтгал, ихэсгэл багасгал, чимэг үгээс гадна тойруулал, ёгтлол, бэлгэдэл зэрэг уран дүрслэлийн аргыг өргөн хэрэглэсэн нь дорно дахины уран сайхны сэтгэлгээний уламжлалт ойлголттой холбоотой юм. Лувсанчүлтэм, Жамьяангарав нар чимгийн мөн чанарыг тайлбарлахдаа “Дандин Анандавархан зэрэг их найрагч онолчдоос яруу найргийн дохиог өгч, ёгтоор өгүүлэх дхаванийн жам ёс баримтлан бичих”-ийг сургасныг дагалдаж байв. Дхаванийн жам ёсны яруу найраг нь үгийг шууд, шилжүүлсэн, далдалсан гурван утгатай байдаг” гэсэн ойлголт баримталж байсан нь өрнө дахины онолоор уран дүрийг бүтээх үндсэн гурван арга байна гэсэнтэй үндсэндээ дүйж байгаа юм. Үүнд,

- 1.Тодорхойлолзүйн арга
- 2.Харьцуулалзүйн арга
- 3.Бэлгэдэлзүйн арга болно

1. Тодорхойлолзүйн аргаар уран дүрсэлсэн нь

Тодорхойлолзүйн арга гэдэг нь аливаа дүр дүрслэлийг бүтээх, түүний мөн чанарыг танин мэдүүлэхдээ өөр адил тастэй эсрэг тэсрэг зүйлтэй харьцуулан жишин илтгээгүй, өөрийн зөн совин зүүд зэрэг байгалиас заяасан сэтгэлийн ухамсарт түшиглээгүй, зохиогчоос гагцхүү өөрийн сайн мэддэг зүйлээ тоочин хэлж, үгээ оновчтой сонгож, утгыг нь нээн гаргаж дүр дүрслэл бүтээхийг хэлнэ.Аливаа дүрийг бүтцийн хувьд шууд, шууд бус, утгын гэж ангилдгаас шууд гэдэг нь аливаа юмны шинж чанарыг гадна буюу дотроос нь шууд тоочин дүрслэх тодорхойлолзүйн аргаар бүтдэг байна.

Хөх судар романы зохиомжид байгалийн зураглал\пейзаж\, тодорхойлол\характеристка\, хүүрнэл\повествование\-ийг тодорхойлолзүйн аргаар тоочин уран дүрсэлснээс хамгийн анхаарал татахуйц сонин содон нь хөрөг дүр\портрет\ юм. Энэ нь их зохиолчийн яруу найрагч, урлагийн онолч, түүхч төдийгүй уран зурагт шамдаж байсан билиг авьяастэй нь салшгүй холбоотой гэж бид үзэж байна. Хөх судар романд гарах 300 гаруй дүрээс гол баатруудыг төрх байдлыг хөрөглөн зурахдаа Инжаннаши үнэхээр дорно дахины хавтгай зургийн аргаар нэг бүрчлэн тоочин тодруулж, хэмжээ харьцаа, өнгө будгийг ялгаруулсан нь нэн гайхалтай. Тухайлбал, Тайзуг “*Тэргэл саран мэт хас цагаан царайтай, төгс гэгээн луугийн нүд ургаад, хангарьдын хоёр хөмсөг өргөн, хамар нь хайрхан уул мэт өндөр, уруул нь оюу болдог адил зузаан, нүүр дөрвөлжин, нуруу урт ил нь арван алхмын газарт сүр гэрэл бадраад, эчнээ нь нэгэн төрийн эзэн суух буян буй*”¹⁶ хэсэгт дорны уламжлалт домогзүйн сэтгэлгээнд хэвшсэн дөрвөн хүчтэнээс луун нүд, хангарьдын хөмсгийг онцлон авч сүр сүлдийг нь илүү тодотгож, эгэл бус заяа, эрдэм чадлын төгс шинжийг түүнээс сацран гийх ер бишийн сүрлэг гэрэл гэгээ бадруулан буйгаар дүрсэлсэн нь тэнгэр заяатайг нь илтгэхээс гадна төрийн эзэн суух хувь ерөөлт шинжийг бэлгэджээ. Энд Гэтэл Жамухыг “*Горлудаас ирсэн Жамуха гэгч нуруу охор, хөл урт, царай шаравтар, нүд тусгал могойн нүд, хулансын харлагатай... бас угаас хулгайн үндэст лайхад аймгийн Сэцэнг бөх хэмээгч уулийн толгой шувууны нүд, чонын завж, мэлхийн сүүжит маш нэгэн болшгүй хүмүүн*”¹⁷ гэж энд дүрийн байдлыг зан төрхтэй харьцуулах аргаар тодорхойлж “ууль шувууны толгой мэт хэлбэртэй, хүйтэн цуст могойн нүд, идэмхий муу чонын завж, дэвхрэн явах мэлхийн сүүжит мэтээр “Зохист аялгууны” бодыг өгүүлэх үлгэрийн

¹⁶⁾ Инжаннаши.В (1957), Хөх судар тэргүүн дэвтэр, ӨМАХХ., 102-р тал.

¹⁷⁾ Инжаннаши.В (1957), Хөх судар, тэргүүн дэвтэр. ӨМАХХ., 157-158-р тал.

чимгээр бүтээсэн нь монголчуудын цээрлэн жийрхдэг амьтас лугаа зүйрлэн үнэлсэн үндэсний мэдрэмж, үнэлэмж бүхий нэгэн давтагдашгүй дүрийг бүтээсэн байна.

Энд зохиолч эерэг талын баатраа гадна өнгө зүс, бие хаа, хувцас хунар, эдлэл хэрэглэлийг унаа мал, зэвсэг сэлттэй нь цөм тоочин зурагласан бол сөрөг талын баатруудаа арай товчхон тодорхойлж, дүрийн зан төрх сэтгэл санааг нь аажим нээсэн нь ажиглагдана. Тухайлбал, Тогтонги баатрыг зохиолд *“Чээж өргөн, нуруу өндөр, бэлхүүс бүдүүн, бие махлаг, улаан магнагийн хуяг дуулга өмсөж, улаан зээрд морь унажээ. Сүүжиндээ төмөр бөмбөг харвах болдын ширхэг, сахиулсан нум агсаж, гартаа их дэм илдийг барьж”*¹⁸ гэсэн бол Хэ ванг *“Тэргүүнд суух Хэ ван хэмээгч царай шар, сахал шингэн, нүд гурвалжин, цэцгий шарангуй, хүн нь төвгүй”*¹⁹ гэжээ.

Үүнчлэн их зохиолч Инжаннаши уран дүрээ бүтээхдээ гадаад хэлбэр нь дотоод агуулгаа илтгэдэг дорно дахины уламжлалт гоо зүйн үзэл “үзэмжид сэтгэлгээг уялдуулах онол”²⁰ үрээр зохиолд өгүүлэгдэх ихэнх дүрийг хөрөглөн дүрсэлж, мөнөөх дүрүүдээ түмэн мянган учир явдал хөдөлгөөнд оруулан зан төрхийг илрүүлэн дүрсэлснээрээ дүрүүд нь уран сайхан боловсорч “амьд” оршиж чаджээ зураглаж. Энд бид хөрөг дүрийг зөвхөн тодорхойлолзүйн аргаар л дүрсэлсэн гэж үзэж болохгүй юм. Учир нь Тайзу богдын хөрөг дүрийг 12 шинжийг илтгэн гаргахдаа “луугийн нүд ургаад” “саран мэт хас цагаан царай” “хангарьдын хоёр хөмсөг” “өргөн хамар нь хайрхан уул мэт” гэж харьцуулалзүйн аргаар уран дүр бүтээсэн байна. Энд “саран мэт хас цагаан царай” гэсэн нь давхар зүйрлэл болно.

“Хөх судар” романд байгалийн зураглалыг монгол зургийн аргаар тоочин хүүрнэсэн төдийгүй зохиомжийн энэ зүйлээр дүрийн сэтгэл санааны хувирал өөрчлөлт, зан төрх илрэх суурь дэвсгэр болгож, дотоод сэтгэлийн зөрчлийг хурцатгаж өгсөн нь олонтоо. Тухайлбал, зохиолд Тайзу богдыг мэндлэх үеийг *“Хараахан дөрвөн сарын улирал тул тас хөх зүлэг өвс хөхрөөд, уулын зуун цэцгүүд дэлгэрч, элдэв зүйлийн болжмор жиргэж, зохистойёо найрамдах цаг...”*²¹ хэмээх байгалийн зураглал нь Өэлүн үжин эх тайван тогтуун санаа сэтгэл амгалан, Тэмүжин богдыг мэндлэхүйеэ нэн зохистой, хаврын салхины зөөлөн шивнээ, зандны сайхан үнэр хамар үнстэн гэхчлэн яруу тунгалаг зураглаж хамаг юм дэлгэрэх найртай цагт их хүн хорвоод мэндлэн буйгаар зурагласан нь онцлог. Харин зохиолын өрнөл хэсэгт Лайхад аймгийн Сэцэн бөхтэй тулалдан бүхүйд салхи шурхиран, цас лавсан орж, Сэцэн бөхийн урьдаас бэлдсэн их даланд цэргүүдийнхээ хамт унаж байна. Энд Бет улсын цэргийн их хохирлыг байгалийн тааламжгүй нөхцөл байдал улам хурцатгаж байна. Зохиолд энэ мэтчилэн дайн байлдаан, зөрчил тэмцэл, уй гуниг, баатрын сэтгэл санааны хямрал хувирлыг салхи шуурга бороо цас зэрэг байгалийн бэрхшээлтэй зэрэгцүүлэн нягт холбон дүрсэлж, баяр баясгалангаар бялхан аз жаргалаар гийсэн, тэнгэрийн ивээлд багтах явдлууд\фабул\ нь байгалийн гоо үзэмж бүрдсэн, сэтгэлд таатай зохистой найртай нөхцөл байдалд өрнөж буйгаар дүрсэлсэн онцлогтой байна.

2.Харьцуулал зүйн аргаар уран дүрсэлсэн нь

Аливаа уран дүрийг бүтээхдээ хоёр юмны адил болон ижил төстэй шинж байдалд нь тулгуурлан харьцуулж адилтгал, зүйрлэл, төлөөлөл, чимэг үг, ихэсгэл, багасгал,

¹⁸⁾ Инжаннаши.В (1957), Хөх судар, тэргүүн дэвтэр. ӨМАХХ., 648-р тал.

¹⁹⁾ Инжаннаши.В (1957), Хөх судар, тэргүүн дэвтэр. ӨМАХХ., 138-р тал.

²⁰⁾ Десрейжав (1993), Их зохиолч Инжаннаши. Бээжин, 41-р тал.

²¹⁾ Инжаннаши.В (1957), Хөх судар, тэргүүн дэвтэр, ӨМАХХ 102-р тал.

хэтрүүлэл зэрэг хэлбэрээр илрүүлэх аргыг уран лүр лүрслэл бүтээх харьцуулалзүйн арга гэдэг.

В.Инжаннашийн Хөх судар романыг уншихад агт морьдын туурай дэлхийг бөмбөрдөн, алалдах дуун чихэнд сонстон, тулааны тоос манарах дайны талбараас тулгын захад суун хууч хэлэлцэх жирийн ард хүртэл, туг хиур, бүрээ бөмбөр нижгэнэх их дуун, их төрийн ёслол найр, цэргийн хүрээний харуул манаа, төрийн чанд цааз, дэг ёсноос эхлэн, ураг барилдах хурим найрын ёслолыг хүртэл нүднээ харагдаж илт тодорхой үзэгдэхүйц дүрсэлсэн увдис чадал нь дорно дахины үлгэр туульсын гүн сэтгэлгээ, үнэр амт нь илт мэдрэгдэм яруу тод дүрслэлээр нь тайлбарлагдана.

1.Адилтгал (метофора) Адилтгал нь хоёр юм үзэгдлийн адил төстэй байдалд үндэслэсэн бөгөөд зүйрлэлээс ялгаатай нь адилтгагдахуун нь адилтахуунаараа илэрдэг. “Үлгэр хийгээд үлгэртэн хоёрыг тусад нь үзүүлэхгүйгээр нэгэн зүйл болгож мөнхүү адилтгал гаргахыг дүрст чимэг хэмээн таалмуй”²²эсвэл “ Аль нэг юм үзэгдлийг нөгөө юмны адил төсөөр нь шилжүүлэн дүрслэх”²³ “Сэтгэл гижигдэх шинжийг нь зориуд тооцсон ухамсарт зүйл”²⁴ гэж онолын ном зохиолд тэмдэглэсэн байна.Зохиолд “Хэрэйдийн нэгэн өтөл бялдууч хөгшнөөс би юунд айх буй. Айх нь Бет улсын эзэн Тэмүжин болно. Түүнийг эртхэн сөнөөхгүй бол удаандаа цөм **тогооны доторх загас** болно”²⁵ хэмээн Жамуха Хе вангийн илч Асурыг ган гачигтай гэж шалтаглан буцаагаад түшмэлүүдтэйгээ ийн хэлэлцдэг. Энд Тайзуг өрсөн устгахгүй бол өөрсдөө ачүүхэнч хүч чадалгүй, амьдран тэнхрэх боломжгүй, нэн доройтон, хүний хоол болж аманд нь оронд гэсэн санааг “ тогоон доторх загас”-т адилтган санааг тойруулжээ. Солонгуан хөрөг дүрийг урлахдаа “ Шунхын уруул **хас ясыг** өмхжээ” гэж танан цагаан шүдийг нь хасын өнгөт ясад үлтгэжээ.

2. Зүйрлэл (сравнение): Хөх судар романд нэн түгээмэл хэрэглэсэн нь зүйрлэл буюу “жишин үйлдэх үлгэртээ ямар мэт байгаа зүйл нь жишигдэх үлгэртэнд мөн тэр янзаар байгааг нь адилтган тодорхойлж, онон үйлдэх нь үлгэрийн чимэг”²⁶ юм. Үлгэрийн чимгийг илэрхийлэх зүйрлэн гийгүүлэх үгст мэт шиг аялгуу, ямарчлан, сацуу, дүрс адил, магад тодорхой, үнэхээр адил, тус тус оногдохуй, түшиг хань, хувь нөхөр, язгуур зохилдох гэс мэт үгс бий. “*Жамуха хаан биеэр тэргүүлэн цэргээ авч, уул юурэх мэт, мөрөн сэтэрсэн адил нэгэн амиар довтлон нэхсээр*”²⁷ “ Эзний захиа Жамухыг хүн бариваас Мянган лан мөнгө шагнаж түмэн өрхийн ноён болгомуй хэмээн олон зэргээр хашгхируулан зарлуулахуйяа цэргийн дотор түрхрэн дуудалцах нь *гол анирлаж, хадын дуу мэт*”²⁸ “*Далай түлхэх, уул нүүх мэтээр байлдахаар ирвэй*”²⁹ “дүгрэг бөмбөгөр нүүр царайд тохирсон *эвхрэн хөвхөлзөх хар бэх адил үүлсийн үс*”³⁰ гэхэд хэлбэр байдал нь эвхрэн хөвхөлзөх үүлс шиг, бас өнгө нь бэхэс адил гэж давхар давхар зүйрлэсэн байна.

²²) Гаадан. Х (1986), Зохист аялгууны толийн адилтгал зүйрлэл, Улаанбаатар.

²³) Дулам.С, Хасбаатар.Ц (1983), Уран зохиолын онолын үүд, Улаанбаатар.

²⁴) Уеллек.Р Уоррен.О (1998), Утга зохиолын онол, Улаанбаатар.

²⁵) Инжаннаши.В (1957), Хөх судар, тэргүүн дэвтэр. Хөх хот.

²⁶) Гаадан.Х (1986), Зохист аялгууны толийн адилтгал,зүйрлэл. Улаанбаатар, 84-р тал.

²⁷) Инжаннаши.В (1957), Хөх судар, тэргүүн дэвтэр, ӨМАХХ., 262-р тал.

²⁸) Инжаннаши.В (1957) Хөх судар, тэргүүн дэвтэр, ӨМАХХ., 347-р тал.

²⁹) Инжаннаши. В (1957), Хөх судар, тэргүүн дэвтэр, ӨМАХХ., 296-р тал.

³⁰) Инжаннаши. В (1957), Хөх судар, ӨМАХХ., 426-р тал.

Их зохиолч Инжаннаши Хөх судар романд дүр төрхийг хөрөглөн зурахдаа “шиг, адил, мэт,” гэх гийгүүлэх үгсийг хураамжлан “гарьд галбингын нүд” “могойн нүд” “хулансын харлага” хэмээн дүрсэлж товч хураангуй зүйрлэлээр уран дүр бүтээсэн нь элбэг байна. Тухайлбал, сөрөг талын баатрын нэг Ялгуугийн дүрийг “Түүний төрсөн нь зурман толгой, зүрхэвчийн нүд, үнэгийн шогшлого, чонын харалттай” гээд толгой, нүд, явдал, харцыг нь зурам, үнэг, зүрхэвч чонын эд эрхтнээр төлөөлүүлэн зохист аялгууны толийн бодыг өгүүлэх үлгэрийн чимгээр бүтээсэн онцлогтой. Ийнхүү хураангуйлан зүйрлэх нь ардын аман зохиолоос уламжлалтай, монголчуудын танин мэдэхүй, үндэсний сэтгэлгээний дадал хэвшилтэй нь холбогдоно. Монгол ардын аман зохиолд тэмээг “хулгана чихтэй, үхэр гэдэстэй, бар тавхайтай, туулай уруултай...” гэхчлэн хураангуй зүйрлэн дүрсэлж ирсэн уламжлал бий.

Хөх судар романд үзэсгэлэнт бүсгүйчүүдийн дүрийг “Солонгуа... цэцгийг ичингүйрүүлж, сарыг гутаамаар сайхан төрсөн”³¹ “Голын саран гүнж... өнгө зүс нь цэцэгт үлтгэшгүй, цэцгээс амтлаг, саранд адилтгаваас сарнаас анхилам... гийвэн цагаан хасын царай нь оо ичээм булбарай нимгэн, улаан өнгөт энгэсгийг хэрэгсэх үгүй”³² хэмээн Солонгуа охины өнгө зүс нь цэцгээс сайхан, Голын саран гүнжийн төрсөн нь саранд үлтгэвээс сайхан үнэртэйн учир сарнаас ч илүү гэх буюу “гийвэн цагаан хасын царай нь оо ичээмээр” хэмээн ер хүний царайг засан гэрэлтүүлэх оо энгэсэг ч түүний царайны сайханд хүрэхгүй хэмээн жиших үлгэртнээ муушаан, жишиглэх үлгэртнээ ямар нэгэн шинжээр түүнээс давуу болохыг илтгэдэг **муушаах үлгэрийн чимгээр** дүрслэн үзүүлсэн байх юм.

3. Ёгтлол (аллегория): Бодит амьдралд байх өрөнхий хийсвэр ухагдахуун үзэгдлийг тодорхой дүрээр тойруу замаар өөр юм үзэгдэлтэй жишин зүйрлэсэн байдлаар илэрхийлэх найруулгын аргыг хэлнэ. Ёгтлолд биет юм үзэгдэл нь хийсвэр ухагдахууны бэлгэ тэмдэг шинж чанартай байна³³.

В.Инжаннашийн туурвил зүйд гоц содон илэрч, түгээмэл ажиглагдах дүрслэлийн нэгэн хэлбэр нь аль нэг талаараа төсөө бүхий юм үзэгдлийг өөр үгээр орлуулж, үндсэн санаагаа далдуур өгүүлэн бүхэл цогц утгыг уран сайхны аргаар гаргасан³⁴ ёгтлол байдаг. Сударт өгүүлэх нь. “Солонгуа нисэх мэт нэхэн ирэхүйд, гэнэт нумны хөвчийн чимээг сонсоод нүдэн хурц тул баруун гараа нэгэнтээ сунгамагц, түүний сумыг атган аваад үзэхүл харин нэгэн зэв үгүй сум ажээ. Өдний хооронд алтат шунхаар долоон одон зуржээ. Солонгуа үүнийг үзээд гэнэт сэтгэл хөдөлж, дотор хөвхөлзөж жимийсхийн өчүүхэн инээгээд, сумыг саадагтаа дүрээд, муруй хөмсгөө баахан атирмагц нэгэн санаан олж, жадаа эмээлийн бүүргэндээ хөндөлдөж хавчуулаад, магнаг хавтагын дотроос нэгэн мөхлөг гаргаж үзвээс, Алтаншагай хараахан инээмсэглэж ирэхүй тул даруй нумаа татаж, тамшаалан илгээв. Алтаншагай лав хариу нэгэн сум харвая даа хэмээн хараахан атаархахүйд жад барьсан гарын ард товхийтэл нэгэн мөхлөг тусч жадаа арай эс алдав. Алтаншагай мөхлөгийг авхуулж үзвэл дээр нь алтнаар мөнх тамга даржээ”³⁵ хэмээн Солонгуа, Алтаншагай хоёр бие биенээ олж харсан даруйдаа ихэд тоомжлон, хиргүй тунгалаг ариун хайр сэтгэлээ

³¹) Инжаннаши. В (1957), Хөх судар, ӨМАХХ., 273-р тал.

³²) Инжаннаши. В (1957), Хөх судар, ӨМАХХ., 544-545-р тал.

³³) Сүхбаатар. Ц (1997), Монгол хэлний найруулга зүй. Улаанбаатар, 197-р тал.

³⁴) Галбаатар. Д (2011), Уран зохиол: онол түүх, шүүмж, Улаанбаатар, 145-р тал.

"*Алтат шунхаар долоон од зурсан сум*", "*Алтнаар мөнх тамга дарсан мөхлөг*"-ийг бие биедээ илгээн хиргүй тунгалаг ариун хайр сэтгэлээ ёгтоор илэрхийлж байна. Энэ дүрслэлд алтат шунхаар долоон од зурсан сум нь Солонгуан нэрийг бэлгэдэн Алтаншагайн сэтгэл сум мэт чиглэнэ гэсэн санаа, Солонгуан мөнх тамгыг алтнаар дарсан мөхлөг нь мөнхөд Алтаншагай лугаа ураг холбосугай гэсэн ёгт санааг илэрхийлж байгаа юм.

Ер нь Найман улсын уран бодолгот Алтаншагай, ухаант гүнж Солонгуа хоёрын хайр сэтгэлээ илэрхийлэх харьцаа холбоог зохиолын туршид ёгтлолын аргаар дүрсэлсэн байна. Тухайлбал,

"*Алтаншагай хошууч Полгуудайн амийг авраад, түүний энгэртнэгэн алтан эрхийвч ба таван өнгийн магнаг хавтгын дотор амсрыг сайтар ширжээ*"³⁶ 267 "*Солонго хавтгын амсрыг ханзалж, доторхи юмыг гаргаж үзвээс солгуу цаасанд багласны дотор нэгэн шижир алтны эрхийвч, өнгө гэрэлд нүд зэргэлмүй, Солонгуагийн сэтгэл нүдний харалтыг даган хөдөлж бас үзвээс алтан эрхийвчийн дээр нэгэн мушгиа таван өнгийн уян торгон утсыг зангидан уяжээ. Солонгуа гараас салгалгүй үзсээр гэнэт түүний ухааныг олж мэдээд санасаргүй нүдний нулимс сэтгэлийн аяар дагаж өнхрөн унав*"³⁷ гэж дүрслээд энэхүү бэлгийн далд санааг "Энэ үзүүрт хоёр юм болбоос түүний бие ба миний биетэй ургуулж дөрвөн өнгийн товчоот оньсого үг болгон илгээжээ. Энэ алтан өргөвч нь Алтан хэмээгч түүний нэр эргэвч хэмээх нь эрх биш хэмээгч үг. Жич. Таван өнгө нь солонгын өнгө, Солонго хэмээх миний нэр, утсаа эрхийвчийн дээр уясан нь "Алтан эрх биш Солонго лугаа зангидмуй" хэмээсэн дөрвөн үг болой"³⁸ хэмээсэн нь гүн гүнзгий санааг битүү ёгтоор илэрхийлсэн байна.

Солонгуа урьд Алтаншагай Полгудайн амийг ааваасаа гуйж ёгт битүү утгат бэлгийн хүргүүлсэнчлэн Найманы жанжин Идэрдовын амийг ахаасаа гуйж нэгэн бэлгийг Алтаншагайд явуулдаг. "*Үзвээс таван өнгийн унгираг утсаар нэг бяцхан нумны хөвчийг хийж дээр нь нэг зуун найман мөхлөгийн цагаан манухын эрхийг хэлхжээ...Солонго гэгч түүний нэр бус уу? Түүний дээр манух эрднийн эрхийн мөхлөгийг хэлхсэн нь манух гэснийг даршуулан хэлвээс танай манай хэмээх үг болох үгүй юу? Бас эрхийг хэлхсэнийг даршуулан хэлвээс эрх дурын эрх хэмээх үгс болох бус уу? Тийн бүхэн нумны хөвчинд хэлхсэн тул хоёр үзүүр нийлэх үгүйн учир эрх хэмээвээс эрх бус тул энэ дөрвөн үсгийг нийлүүлэн уншваас "Солонгуа миний эрх бус" гэсэн үг болох бус уу?... Нумны арал нь хатуу чийргийг эрхэлж, аргын амьсгалд харъяатай, арга хэмээгч эр хүн, нумын хөвч хэмээгч уян зөөлнийг мөрдөж билгийн амьсгалд харъяатай, билэг хэмээгч эхнэр хүмүүн, нумын аралд хөвч хөвчилвөөс хоёулаа нийлжсая нэг нум болмуй. Хэрвээ арал үгүй хөвч болвоос эр үгүй эхнэр, эр үгүй эхнэр хэмээгч харилаагүй охин хүн болой... улаан хив хэмээгч түүний ув улаан чин үнэн цусан сэтгэл хэмээсэн санаа, нум ба хөвчийг хэрэглэсэн нь над лугаа эрх биш эр эм болсугай хэмээх санаа, бүгдийг нийлүүлэн хэлвээс" Охин Солонгуа чин үнэн цусан сэтгэлээс чам лугаа эр эм болсугай хэмээн санавч, чадвар үгүй охин Солонгуа миний эрх бус" хэмээсэн үгс болох болой"³⁹ гэсэн энэхүү дүрслэлд өгүүлэх **таван өнгийн эрэн лад цаас** утсаар хийсэн өчүүхэн нумны **хөвч, таван өнгийн утас**, час улаан шинэхэн **хивторго, зууннайман***

³⁶) Инжаннаши.В (1957), Хөх судар, ӨМАХХ., 267-р тал.

³⁷) Инжаннаши.В (1957), Хөх судар, ӨМАХХ., 293-р тал.

³⁸) Инжаннаши.В (1957), Хөх судар, ӨМАХХ., 294-р тал.

³⁹) Инжаннаши.В (1957), Хөх судар, ӨМАХХ., 398-399-р тал.

ширхэг манух эрхи цөм дор бүртээ ёгт битүү утгыг агуулж, ухаан мэргэн хөвгүүн ухамжлан бодохуйяа угаас илгээсэн эзний санааг онон тайлаад баясан буйгаар дүрсэлжээ. Энэ мэт ерийн нэгэн хүн ухан ойлгоход бэрх оньсого мэт ёгт дүрслэлээр Алтаншагай, Солонгуан дүрийг гүн сэтгэмжтэй, уран бодолготой цэцэн билэгтэн болохыг товойлгон харуулсан байна.

Ер нь зохиолд ёгт утгат битүү үг хэлэлцэх, ёгт үйлдэл үзүүлэх, бэлэг илгээх нь зөвхөн эерэг талын баатруудын дүрийн харьцаан дээр л илэрч байгаа нь дүрийн зан төрхийг илрүүлэх тохироо болж байна. Тайзу Мухулай хоёрын харилцаанд дайн тулааны өмнө арга тактикийг шийдэхдээ эсвэл харь улсын элч бараалхах үед хамтын шийдвэр гаргахдаа дохио тэмдэг, ерийн нэгэн үйлдлээр гүнзгий санааг илэрхийлж буйг зохиолд дүрсэлсэн нь түгээмэл. Тухайлбал, судрын 22-р бүлэгт Тохмог улсыг дайлахдаа Мухулай Бет улсын цэрэг тулалдахаар айсуй хэмээн их цуу үг дэгдээн бүтэн нэг хавар, нэг зун цэргийг нь ер амруулалгүй түгшээсээр, энэ завсар өөрийн цэрэг болон Сарлаг улсын цэргийг сургуулилан, морь малаа бэлчээрийн сайныг сонгон идэшлүүлж таргалуулаад, Тохмог улсынхан залхаж назгайрсан найман сарын шинийн наймнаа гэнэт дайрдаг. Ингэхдээ Тохмог улсын захад сахин суугаа Зүч, Цагаадай хоёр жанжинд элч илгээн бэлэг илгээснийг үзвэл *“Нэг маш их хэтийн улавч төмөргүй гагц хоосон улавчийг илгээжээ. Нээж үзвээс хэтийн төмөр ба цахиурыг цөм дотор нь хийжээ”*⁴⁰ Зүч цагаадай хоёр Тогтонги баатар, Бичгийн багш Замбал нартай зөвлөхөд Замбал. “Энэ лав бидний цэрэг хэдэн удаа Тохмогийн зах хүрээд эс байлдсан тул тэд лав биднийг төмөргүй хэтээр мэдэв. Тийнхүү хэт төмөр ба цахиурыг дотор нь хамтаар хийсэн нь маньг галгүй хэмээн бодож байтал гэнэт гал гарч ирүүл гэсэн санаа. Лав биднийг Тохмогийн олон сул сэрэмжгүй болсонд гэнэт орж нэг удаа байлдаж үз” гэжээ. Энэ үнэхээрийн гайхалтай бөгөөд монголчууд хэдийнээс элч илгээн захиа бариулдаггүй “эмээлийн дуу” элчид цээжлүүлэн зарж “хэлэх үг элчийн аманд” хэмээн хэлэлцдэг болохоос өмнө үеэс улбаатай бас нэгэн ёгт утгат өвөрмөц захидлын хэлбэр ч гэж үзэж болох юм.

Дүгнэлт

Энэ бүхнээс үзэхэд В.Инжаннашийн "Хөх судар" романд уран дүр бүтээх тодорхойлолзүй харьцуулал зүйн аргыг хэрхэн ашигласныг зохиолын хэлд задлан шинжилж үзэхэд

- В.Инжаннаши Хөх судар романд хөрөг дүр, байгалийн зураглалыг тодорхойлолзүйн аргаар хүүрнэн бичсэн бөгөөд хөрөг дүрд гадаад шинжийг тод томруун тоочин зураглаж, байгалийн зураглал нь дүрийн сэтгэлзүй өнгө аястай шууд хамааралтай дүрслэгдсэн онцлог байна.

- "Хөх судар" романд уран дүр бүтээх хэрэглүүрүүдээс зүйрлэл, чимэг үгийг хамгийн түгээмэл ашигласан байна.

- "Хөх судар" романд дорно дахины яруу найргийн онол Дандины Зохист аялгууны толийн муушаах болон бодийг өгүүлэх үлгэрийн чимгээр дүрсэлсэн нь арвин. Мөн "олноос хэтийдсэн", "бүхнээс тасархай", "адилтгашгүй", "үлтгэшгүй" гэх мэтийн үгсээр үнэмлэхүй зэргийг илэрхийлэн, зүйрлэн жиших юмгүй гэсэн нэгэн өвөрмөц зүйрлэлийг бүтээсэн байна.

⁴⁰⁾ Инжаннаши.В (1957), Хөх судар, ӨМАХХ., 772-р тал.

• "Хөх судар" романд зохиолч болгон түгээмэл хэрэглээд байдаггүй, уран дүрслэлийн ёгтлолын аргыг өргөн хэрэглэсэн нь ихэд сонин содон өгүүлэмжийг бүтээсэн байна. Зохиолд ёгт утгат битүү үг хэлэлцэх, ёгт үйлдэл үзүүлэх, далд утгат ёгт бэлэг илгээх нь зөвхөн эерэг баатруудын дүрийн харьцаан дээр л илэрч, уран дүрийн зан төрх илрүүлэх нөхцөл байдал, тохироо болж байна.

НОМ ЗҮЙ

1. АЛТАН ТҮЛХҮҮР. 1992. №3.
2. Баасанбат. Д (2009), "Хөх судар"-ын хэвшмэл хэлц хэллэгүүд, Улаанбаатар.
3. Баасанбат. Д (2007), "Хөх судар"-ын хоршоо үгийн сан, Улаанбаатар.
4. Байгальсайхан. (1998), Уран дүрийн онолын лекцүүд. Улаанбаатар.
5. Билигсайхан.Ч(1984), Орчин цагийн монгол роман. Улаанбаатар.
6. Буянбат.Г (1988), Инжаннаши ба түүний Хөх сударын тухай. Хөх хот.
7. Гаадан.Х(1986), Зохист аялгууны толийн адилтгал зүйрлэл. Улаанбаатар.
8. Галбаатар.Д (2011), Уран зохиол: онол түүх, шүүмж, Улаанбаатар.
9. Десрейжав (1993), Их зохиолч Инжаннаши. Бээжин.
10. Дулам.С Хасбаатар.Ц (1983), Уран зохиолын онолын үүд. Улаанбаатар.
11. Дэлгэр (1988), Хөх судрын гол баатрын зан чанарын бүтэц ба систем.
12. ӨМИС-ийн ЭШС.1988. №3.
13. ӨМИС-ийн ЭШБ.1982. №2.
14. ӨМҮБДС-ийн ЭШБ.1983. №1.
15. Инжаннаши. В (1957), Хөх судар. тэргүүн дэвтэр. ӨМАХХ.
16. Инжаннаши. В (1957), Хөх судар. дэд дэвтэр. ӨМАХХ.
17. Михайлов. Г, Яцковская. (1969), К. Монгольская литература. Москва.
18. МОНГОЛ ХЭЛ УРАН ЗОХИОЛ. 1983, №1.
19. ӨМҮБДС-ийн ЭШБ. 1983, №1.
20. Сүхбаатар. Ц (1997), Монгол хэлний найруулга зүй. Улаанбаатар.
21. Тимофеев. Л. И (1959), Основы теории литературы. Москва.
22. Уеллек.Р Уоррен.О (1998), Уран зохиолын онол. Улаанбаатар.
23. Энхбаяр.С (2011), Утга зохиолын онол. Улаанбаатар.

SUMMARY

The paper studied some features of the literary language of the novel “The Blue Chronicle of the great Yuan’s risen state” which written by well-known writer Injannashi.V in 19th century. It described the creature of characters from descriptive and comparative perspectives.

Injannashi narrated especially character portraits and native scenes using descriptive method. It also found that nature scene directly connected to psychological tones and emotions of the characters.

Metaphors, comparisons and epithets are commonly used in the “Blue chronicle” among the figures of speech.

Absolutness and in comparison are described with special expressions such as “the best of others”(olnoos hetiidsen, tsolgotson, bukhnees tasarkhai) “incomparable”(adiltgashgui, ultgeshgui) “unequaled”(tentseshgui, zuirleshgui) and unmatched.